



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
МАТЕМАТИК, ТООН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЕМИНАР

2020 оны 1 сарын 17, Баасан гараг, 15:00 цаг,
Академич Б.Чадраагийн нэрэмжит танхим /Өрөө 320/

Докторант П.Нямсүрэн /ШУТИС/

Өгөгдөл олборлолтонд тулгуурласан байгууллагын хөгжлийн үнэлгээний систем” (Дээд боловсролын сургалтын байгууллагын жишээн дээр)

Судалгааны ажлын товч танилцуулга: Судалгааны ажлаар гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг тодорхойлох онол арга зүй, загварыг боловсруулан санал болгох, санал болгож буй загварыг дээд боловсролын сургалтын байгууллагын жишээн дээр хэрэгжүүлэн бататгаж гүйцэтгэлд суурилсан үнэлгээний систем, үнэлэх аргачлалыг тодорхойлон санал болгох юм.

Судалгааны ажлын шинэлэг тал: Энэхүү судалгааны ажлын үр дүн болох Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт нь их, дээд сургуулиудын гүйцэтгэлийг үнэлэх, цаашлаад эрэмбэ тогтоох ажлыг одоогийнхоос илүү өргөн хүрээтэй болгон сайжруулахад хувь нэмэр оруулах.

Практик ач холбогдол: Судалгааны ажлын хүрээнд боловсруулагдсан арга зүй, судалгааны үр дүн, шийдлүүдийг төр засаг, бизнесийн болон боловсролын байгууллагууд төдийгүй байгууллагын хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, хөгжлийн түвшинг үнэлэх, харьцуулахад ашиглах боломжтой.

Судалгааны арга зүй: Системийн судалгаа, Бодлогын судалгаа, түүвэр судалгаа, шинжээчийн үнэлгээний арга, Simple Additive Weighting method, Analytic Hierarchy Process аргачлал болон өгөгдөл олборлолтын outlier's, аргачлал, математик статистикийн арга зэргийг ашигласан ба үзүүлэлтүүд, загварын тооцооллыг MS office, SPSS, WEKA, MATLAB зэрэг програмуудаар гүйцэтгэв.